



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,  
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,  
Утас: (705) 2-27-34

2019.02.26 № 1-6/20  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

ӨРГӨН СУМЫН ЗАСАГ  
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА  
О.ЦАСАНЦЭЦЭГ ТАНАА

**Аудитын гэрчилгээ**

**Санал дүгнэлт өгөхөөс татгалзах**

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг үнэлж, Өргөн сумын Засаг даргын тамгын газрын 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу хуульд заасан хугацаанд ирүүлээгүй тул санал дүгнэлт өгөхөөс татгалзаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

**Аудитын гол асуудал**


Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1 "төсвийн шууд захирагч жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг дараа оны 01 дүгээр сарын 25-ны дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн санхүүгийн тайланг 02 дугаар сарын 25-ны дотор харьяалагдах дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэх", Төрийн аудитын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 "Засгийн газар болон бусад байгууллагууд жилийн эцсийн санхүүгийн тайлангаа нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу гаргаж Төсвийн тухай хуулиар тогтоосон хугацаанд төрийн аудитын байгууллагад ирүүлнэ" гэж заасан байхад Өргөн сумын Засаг даргын тамгын газар 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгосон төсвийн гүйцэтгэл болон санхүүгийн тайлангаа Төрийн аудитын байгууллагад ирүүлээгүй байгаа нь цаг хугацааны хязгаарлалтад оруулж аудит хийхэд цар хүрээний хязгаарлалтыг бий болгож байна.

Өргөн сумын Засаг дарга  
О.ЦАСАНЦЭЦЭГ ТАНАА

## Үүрэг, хариуцлага

Өргөн сумын Засаг даргын тамгын газар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, хуульд заасан хугацаанд тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллага үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ч.АРИУНАА

